



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө ашиглах хугацаа, үнийг шинэчлэн
тогтоож балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 51,690,707.00 (тавин нэгэн сая зургаан зуун ерэн мянга долоон зуун долоо) төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Дархан-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоо, “Дархан-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Баясгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашинь улсын дугаарын шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 06 дугаар сарын 15-ны
өдрийн 1/21 дүгээр тогтоолын хавсралт



**"ДБҮЭГ" ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг цаашид
ашиглах жил үнийг шинэчлэн тогтоож "Дархан-АЗЗА" ТӨХК-д балансаас
балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон огноо	Балансын, хуримтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ	Цаашид ашиглах хугацаа
1	Хьюндай Старекс маркийн, 25-22 УНУ улсын дугаартай, суудлын автомашин арлын дугаар- KMJWWWН7WP7U759992	2007/2008	23,282,550.00	4,656,510.00	2 жил
2	Ниссан маркийн, 93-45 УБГ улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар- JNIBCAC11Z0013964	2008/2008	28,408,157.00	5,681,631.00	2 жил
			51,690,707.00	10,338,141.00	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		51,690,707.00 (тавин нэгэн сая зургаан зуун ерэн мянга долоон зуун долоо)	10,338,141.00 (арван сая гурван зуун гучин найман мянга нэг зуун дөчин нэг)	